



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 571

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө ашиглалтын шаардлага хангахгүй нийт 84,584,500.00 (наян дөрвөн сая таван зуун наян дөрвөн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 6 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Түдэвдагва, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Г.Сарантуяа, Өвөрхангай, Хэнтий, Ховд аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

132001556

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
...../дугаар тогтоолын хавсралт

**УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори					
1	УАЗ-22069-033 пургон маркийн, микроавтобус зориулалттай, 43-02 УБН улсын дугаартай, арлын дугаар 80438875	2007	998,851	13,700,000.00	1,500,000.00
2	Ниссан санни маркийн суудлын автомашин, 07-43 УНП улсын дугаартай, хөдөлгүүрийн багтаамж 1295, арлын дугаар В15023062	2004	247,400	9,000,000.00	1,000,000.00
Өвөрхангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв					
3	УАЗ-220693303 пургон, 87-07 ӨВА улсын дугаартай, тусгай зориулалтын, хөдөлгүүрийн дугаар 71105496, арлын дугаар 80450346	2008	219,000	14,600,000.00	2,000,000.00
Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн					
4	Тоёота спасио маркийн суудлын автомашин, 71-63 УБП улсын дугаартай, хөдөлгүүрийн дугаар 324570, арлын дугаар АЕ111-6122750	1999	195,142	8,284,500.00	1,000,000.00
Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв					
5	Тоёота Ланд круйзер 80 маркийн суудлын автомашин, 68-18 ХЭА улсын дугаартай, хөдөлгүүрийн дугаар 0042772, арлын дугаар HDJ810021739	1992	362,765	16,000,000.00	2,500,000.00
Ховд аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв					
6	Тоёота Ланд круйзер 80 маркийн суудлын автомашин, 00-46 ХОА улсын дугаартай, арлын дугаар HDJ810067167	1996	12,500	23,000,000.00	3,500,000.00
				84,584,500.00	11,500,000.00
НИЙТ ДҮН				(Наян дөрвөн сая таван зуун наян дөрвөн мянга таван зуун төгрөг)	(Арван нэгэн сая таван зуун төгрөг)